

ЭРСДЭЛД СУУРИЛСАН АУДИТААР САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Ч.Анхбаяр*, Б. Очирсүх**

Хураангуй: Санхүүгийн эрсдэлийг тодорхойлох нь компанийн засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт болон санхүүгийн бодлогын нэн тэргүүний асуудал байдаг. Санхүүгийн эрсдэлийг тоон болон чанарын үнэлгээгээр тодорхойлж болох ба энэхүү судалгааны ажлаар эрсдэлд суурилсан аудитын чанарын үнэлгээг авч үзнэ. Тус чанарын үнэлгээ нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд тулгуурласан эрсдэлийн түвшинг тодорхойлох 163 асуултаас бүрдэнэ. Санал асуулгыг бид 10 салбарын нийт 55 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан авсан ба үр дүнд санхүүгийн тайлангийн 6-13 хувь нь эрсдэлийн түвшин өндөр, 3-11 хувь эрсдэлийн түвшин маш өндөр гэсэн ангилалд хамаарагдах магадлалтай байна. Эрсдэлд суурилсан аудитаар санхүүгийн эрсдэлийг тодорхойлоход дансны авлага, хуримтлагдсан ашиг эрсдэл дунд, бусад үзүүлэлтүүдийн хувьд эрсдэл бага байна.

Түлхүүр үгс: Аудитын онолууд, эрсдэлийн үнэлгээний арга зүй, эрсдэлийн түвшин

IDENTIFYING FINANCIAL RISKS THROUGH RISK-BASED AUDITING

Abstract: Identifying financial risks is a priority in corporate governance, strategy, risk management, internal control, and financial policy. Financial risks can be assessed both quantitative and qualitatively, and this study focuses on the qualitative evaluation of risk-based auditing. This qualitative assessment consists of 163 questions designed to determine the level of risk based on financial statement indicators. We conduct the survey among 55 business entities across 10 different industries. The results indicate that 6–13% of financial statements are classified as high-risk, while 3–11% fall under the category of very high risk. When identifying financial risks through risk-based auditing, accounts receivable and retained exhibit moderate risk, whereas other financial indicators show lower risk levels.

Keywords: Audit theories, risk assessment methodology, risk level.

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (email) ankhbayar.ch@num.edu.mn

** МУИС-ийн Бизнесийн сургуулийн магистрант, (email) b.ochiroo0202@gmail.com

Удиртгал

Эрсдэлд суурилсан аудит нь нэг талаас байгууллагын санхүүгийн тайлангийн эрсдэлтэй хэсгүүдэд төвлөрч, тайлангийн найдвартай байдлыг хангахад дэмжлэг үзүүлдэг. Нөгөө талаас санхүүгийн эрсдэлийг тодорхойлсноор аудитын ажлыг илүү үр дүнтэй болгодог. Монголын бизнесийн орчинд байгууллагуудын санхүүгийн тайлангийн эрсдэлийг тодорхойлох, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах хэрэгцээ улам нэмэгдсээр байна. Санхүүгийн тайлангийн алдаатай мэдээлэл, зөрчил, эрсдэл нь байгууллагуудын санхүүгийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын шийдвэр, хууль эрх зүйн үүрэг хариуцлагад сөрөг нөлөө үзүүлдэг. Эрсдэлд суурилсан аудитын гол онцлог нь санхүүгийн тайлангийн бүх элементэд бус, хамгийн эрсдэлтэй хэсгүүдэд төвлөрөх явдал юм. Энэ нь аудитын ажлын цар хүрээг оновчтой болгох, байгууллагын санхүүгийн тайлагналын чанарыг сайжруулахад тусалдаг.

Эрсдэлд суурилсан аудитын хөгжлийн үйл явц, онол, практик, түүнчлэн компаниудын санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг Simunic (1980) болон Knechel (2007) нар судалж, эрсдэлд суурилсан аудитын үүрэг, ач холбогдлыг онцолсон. Christopher et. all (2017) нар эрсдэлд суурилсан аудитын онолын үндсийг тодорхойлж, санхүүгийн аудитын процессыг тайлбарлажээ. Manson болон Zaman (2001) нар эрсдэлд суурилсан аудит нь санхүүгийн тайлангийн чанарыг сайжруулж, үүсэх алдаанаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэйг нотолсон. Түүнчлэн компанийн засаглалд эергээр нөлөөлдөг болохыг Demaki (2018) харуулсан. Дотоод хяналтын системийг эрсдэлд суурилсан аудиттай холбон Arens et al. (2017) болон Pickett (2011) нар судалсан. Тэдний бүтээлүүд эрсдэлд суурилсан аудит нь дотоод хяналтын сул талыг илрүүлэх, засварлах, үр ашгийг сайжруулахад чиглэгдсэн. Дотоод хяналтын сайжруулалт нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад нөлөөлдөг (Hayes, 2014).

Манай орны хувьд жижиг, дунд бизнесийн санхүүгийн эрсдэлийг үнэлэх (Даваажав, 2017), жижиг бизнесүүдийн санхүүгийн эрсдэлийг хянах, удирдах арга хэрэгслүүдийг сайжруулах (Отгонбаяр, 2017), байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангах (Энхцэцэг, 2020), санхүүгийн тайлангийн эрсдэлд суурилсан шалгуурыг тогтоох (Мөнхтуяа, 2020), банкны салбарт эрсдэлийг удирдах, хянах механизмыг тодорхойлох (Цэцгээ, 2021) зэрэг эрсдэлд суурилсан аудитын талаар хэд хэдэн судалгааны ажлууд хийгдсэн. Эдгээр судлаач нараас ялгаатайн санхүүгийн эрсдэлээ тодорхойлж чадах мэргэжилтнүүдээс санхүүгийн тайлангийн үзүүлэлт тус бүрээр асуулга авч, үүнд үндэслэн санхүүгийн эрсдэлийг тодорхойлох нэгэн хувилбарыг дэвшүүлсэн нь энэхүү судалгааны ажлын гол онцлог юм.

Эрсдэлд суурилсан аудитын гол зорилго нь эрсдэлийн менежментийг

сайжруулж, санхүүгийн тайлангийн алдаа, дутагдлыг засварлахад чиглэгддэг. COSO болон IFAC зэрэг олон улсын мэргэжлийн байгууллагууд эрсдэлд суурилсан аудитын стандарт, удирдамжийг 2013 онд боловсруулж түгээснээр эрсдэлд суурилсан аудитын талаарх ойлголт, үзэл баримтлал, практик хандлагууд эрчимтэй нэмэгдсэн. Монгол улсын хувьд эрсдэлд суурилсан аудитын талаарх судалгаа харьцангуй шинэ сэдэв юм. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт 2020 онд эрсдэлд суурилсан аудитын аргачлалыг компаниудад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, практик зөвлөмж гаргасан. Энэхүү судалгааны ажлаар аудитын практик дээр тулгуурласан эрсдэлийн асуулгыг боловсруулж, эрсдэлд суурилсан аудитын санхүүгийн эрсдэлийг тодорхойлно.

Судалгааны ажил дараах бүтэцтэй байна. Хоёрдугаар хэсгээр эрсдэлд суурилсан аудитын онолын хандлагуудыг тоймлоно. Гуравдугаар хэсгээр өөрсдийн арга зүйг санал болгоно. Дөрөвдүгээр хэсгээр эрсдэлийн санал асуулгыг нэгтгэн, санхүүгийн эрсдэлийг үнэлнэ. Сүүлийн хэсэгт нь судалгаатай холбоотой үр дүнг нэгтгэнэ.

Эрсдэлд суурилсан аудитын онолын тойм

Эрсдэлд суурилсан аудитын онолын чиглэлүүд нь санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, хянахад чиглэгддэг.

1. Эрсдэлийн менежментийн онол

Эрсдэлд суурилсан аудит нь эрсдэлийн менежментийн үндсэн зарчимд тулгуурлан санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах үйл явцыг хамруулдаг. Тус онол нь санхүүгээс гадна үйл ажиллагааны эрсдэлийг удирдахад чиглэгддэг.

2. Санхүүгийн шинжилгээний онол

Санхүүгийн үзүүлэлтүүдийг ашиглан байгууллагын санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийх замаар эрсдэлийг тодорхойлно. Санхүүгийн шинжилгээ нь байгууллагын санхүүгийн байдлыг үнэлэх, түүнд тулгарч болох эрсдэлийг тодорхойлдог.

3. Аудитын нөөцийн хуваарилалт

Аудитын нөөцийн хуваарилалт нь аудитын үр дүнг сайжруулан байгууллагын санхүүгийн найдвартай байдлыг ханган эрсдэлийг бууруулдаг. Аудитын нөөцийг оновчтой хуваарилснаар эрсдэлийг үр дүнтэй удирдах, хянах

боломж нэмэгдэнэ.

4. Эрсдэлийн хяналтыг тогтоох

Эрсдэлийн хяналтыг тогтоох онол нь санхүүгийн тайлангийн алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналтын системийг сайжруулахад чиглэгддэг. Эрсдэлд суурилсан аудитын онолын хүрээнд, санхүүгийн тайлангийн алдааны эрсдэлийг тодорхойлдог.

5. Дотоод хяналтын загвар

COSO-ийн дотоод хяналтын загвар нь санхүүгийн мэдээллийг найдвартай болгох, эрсдэлийг бууруулах, хяналтын механизмыг сайжруулахад чиглэгддэг. Байгууллагын дотоод хяналтын механизмаар санхүүгийн тайлагналын тогтолцоо сайжирна.

Эрсдэлийн үнэлгээний арга зүй

Эрсдэлийн түвшинг маш бага (VL), бага (L), дунд (M), өндөр (H), маш өндөр (VH) гэж 5 хэсэгт ангилъя. Ангилал бүр нь 5 асуултаас бүрдэх ба нийт асуултын тоо 25 байна. Санхүүгийн шалгуур үзүүлэлтийг (F), түүний тоог (m) гэвэл эрсдэлийн түвшин бүрд харгалзах магадлал

$$P_j^m = \frac{\sum_{i=1}^5 F_{ij}^m}{\sum_{i=1}^{25} \sum_{j=1}^5 F_{ij}^m}, \quad j = VL, L, M, H, VH \quad (1)$$

гэж тооцогдоно. Харин эрсдэлийн интервалд харгалзах тоон утгыг доорх тодорхойлолтыг ашиглан тогтооно.

Тодорхойлолт 1. Хэрэв болзошгүй тохиолдлын магадлал $P \in \{1,2,3,4,5\}$, түүний үр дагавар $L, \in \{1,2,3,4,5\}$ гэсэн бүхэл тоон элементүүдийг авдаг бол эрсдэлийг $R = L \cdot P$ гэсэн тэгшитгэлээр тооцно.

Тодорхойлолт 2. Эрсдэлийн тооцогдсон утгат харгалзах рангийн минимум утгыг R_{min} , рангийн максимум утгыг R_{max} гэвэл эрсдэлийн интерваллыг

$$\Delta R = \frac{R_{max} - R_{min}}{5} \quad (2)$$

гэсэн томъёогоор тооцно. Энд ΔR -г эрсдэлийн интервал гэнэ.

Тодорхойлолт 1-т үндэслэн давхардаагүй тооны бүх хослолын үр дүн

$$R = L \cdot P = \{1,2,3,4,5\} \times \{1,2,3,4,5\} = \{1,2,3,4,5,6,8,9,10,12,15,16,20,25\} \quad (3)$$

байна. Энд багаас нь их рүү дараалуулсан 1-ээс 14 хүртэлх тоо байгаа тул $R_{max} = 14$, $R_{min} = 1$ байна. Тодорхойлолт 2-оос эрсдэлийн интервал нь 3 гэж олдоно. Тус интерваллыг ашиглан рангийн утгыг 1-3, 4-6, 7-9, 10-12, 13-14 гэж ангилан хуваана. Харин эдгээр рангийн ангилалд харгалзах эрсдэлийн утгууд нь 1-3, 4-6, 7-10, 11-16, 17-25 байна. Иймд цаашид эрсдэлийн утга 1-3 бол эрсдэл маш бага, 4-6 бол эрсдэл бага, 7-10 бол эрсдэл дунд, 11-16 бол эрсдэл өндөр, 17-25 бол эрсдэл маш өндөр гэж ангилагдана.

Энэхүү ангилалд харгалзах эрсдэлийн дундаж интервалын утга болон томъёолол (1)-д авч үзсэн магадлалын утгуудын жигнэсэн нийлбэрээр хүлээгдэж буй эрсдэл дараах байдлаар тооцогдоно.

$$E(R^m) = 2P_{VL}^m + 5P_L^m + 8.5P_M^m + 13.5P_H^m + 21P_{VH}^m \quad (4)$$

Асуулгын үр дүн

Эрсдэлд суурилсан аудитын санал асуулгыг авахдаа 10 салбарын 55 аж ахуй нэгж байгууллагыг хамруулав. Эдгээрт бөөний худалдаа, эрүүл мэнд, аудит, хүнсний үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл, боловсрол, даатгал, үл хөдлөх хөрөнгө, банк бус санхүүгийн байгууллага, хүнсний худалдаа зэрэг салбарууд хамаарагдана. Санал асуулганд 35 нягтлан бодогч, 14 аудитор, 4 санхүүгийн менежер, 2 хяналтын менежер оролцов. Ажиллагсдын тооны хувьд 200 хүртэлх ажилчинтай 47 байгууллага хамрагджээ. Хүснэгт 1-ээс харна уу.

Асуулгад оролцсон 55 аж ахуй нэгж байгууллагаас эрсдэлд суурилсан аудитын системийг хэрэгжүүлдэг үү гэж асуухад 55 хувь нь үгүй, 40 хувь нь тийм, 5 хувь нь мэдэхгүй гэжээ. Мөн тус асуулттай холбоотой аудитын хэрэгжилт байгууллагын аль үйл ажиллагаанд илүү их анхаардаг вэ гэж асуухад 58 хувь нь борлуулалт ба санхүүгийн хяналт, 21.8 хувь нь үйлдвэрлэлийн шат дамжлага, 12.7 хувь нь түүхий эдийн чанар ба аюулгүй байдал, 7.3 хувь нь бараа бүтээгдэхүүн тээвэрлэлт ба хадгалалт гэж хариулжээ. Хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 1. Байгууллагын санал асуулгын үндсэн мэдээлэл

Албан тушаал		
Мэргэжилтэнгүүд	Хамрагдсан тоо	Хувь
Нягтлан бодогч	35	63.6%
Аудитор	14	25.5%
Санхүүгийн менежер	4	7.3%
Чанарын хяналтын менежер	2	3.6%
Салбарууд		

Салбарын ангилал	Хамрагдсан тоо	Хувь
Бөөний худалдаа	9	16.4%
Эрүүл мэнд	8	14.5%
Аудит	7	12.7%
Хүнсний үйлдвэрлэл	7	12.7%
Боловсруулах үйлдвэрлэл	6	10.9%
Боловсрол	5	9.1%
Даатгал	4	7.3%
Үл хөдлөх хөрөнгө	3	5.5%
Банк бус санхүүгийн байгууллага	3	5.5%
Хүнсний худалдаа	3	5.5%
Ажиллагсдын тоо		
Ажиллагсдын ангилал	Хамрагдсан тоо	Хувь
1-50 хүртэл	30	54.5%
51-200 хүртэл	17	30.9%
201-400 хүртэл	3	9.1%
401-с дээш	5	5.5%

Эх сурвалж: Санал асуулгын нэгтгэл

Хүснэгт 2. Эрсдэлд суурилсан аудитын асуулгын үндсэн мэдээлэл

Танай байгууллага эрсдэлд суурилсан аудитын системийг хэрэгжүүлсэн үү?		
Үгүй	30	54.5%
Тийм	22	40.0%
Мэдэхгүй	3	5.5%
Эрсдэлд суурилсан аудитын хэрэгжилт нь танай байгууллагын аль үйл ажиллагаанд илүү анхаардаг вэ?		
Борлуулалт ба санхүүгийн хяналт	32	58.2%
Үйлдвэрлэлийн шат дамжлага	12	21.8%
Түүхий эдийн чанар ба аюулгүй байдал	7	12.7%
Бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт ба хадгалалт	4	7.3%

Эх сурвалж: Санал асуулгын нэгтгэл

Эрсдэлд суурилсан аудитын санал асуулга нь санхүүгийн 8 шалгуур үзүүлэлтийн нийт 163 асуултаас бүрдэнэ. Нийт асуултаа дотор нь задалбал бэлэн мөнгө 23, дансны авлага 24, бараа материал 31, эргэлтийн бус хөрөнгө 25, богино хугацаат өр төлбөр 16, урт хугацаат өр төлбөр 15, эздийн өмч 15, хуримтлагдсан ашиг 14 асуултаас бүрдэж байна. Эдгээр асуултуудын жагсаалтыг хавсралт А-с харна уу.

Хавсралт А-д жагсаасан эрсдэлд суурилсан аудитын асуулга нь эрсдэл багатайгаас их рүү гэсэн дарааллаар эрэмбэлэгдсэн. Доорх хүснэгтэд эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт, тухайн жагсаалтад сонгогдсон нийт хариултын тоо, түүний магадлал зэргийг харуулав.

Хүснэгт 3. Эрсдэлд суурилсан аудитын нийт хөрөнгө талын санал асуулгын нэгтгэл

Бэлэн мөнгө			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-5	96	50%
Эрсдэл бага	6-9	33	17%
Эрсдэл дунд	10-13	27	14%
Эрсдэл өндөр	14-18	17	9%
Эрсдэл маш өндөр	19-23	19	10%
Нийт дүн		192	100%
Дансны авлага			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-5	54	40%
Эрсдэл бага	6-9	34	25%
Эрсдэл дунд	10-14	18	13%
Эрсдэл өндөр	15-19	17	13%
Эрсдэл маш өндөр	20-24	12	9%
Нийт дүн		135	100%
Бараа материал			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-7	85	49%
Эрсдэл бага	8-12	44	26%
Эрсдэл дунд	13-18	22	13%
Эрсдэл өндөр	19-24	10	6%
Эрсдэл маш өндөр	25-31	11	6%
Нийт дүн		172	100%
Эргэлтийн бус хөрөнгө			

Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-5	55	40%
Эрсдэл бага	6-10	39	28%
Эрсдэл дунд	11-15	23	17%
Эрсдэл өндөр	16-20	12	9%
Эрсдэл маш өндөр	21-25	10	7%
Нийт дүн		139	100%

Эх сурвалж: Магадлалын утгыг (1) томъёоллыг ашиглан тооцов.

Хүснэгт 3-с бэлэн мөнгөтэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын эрсдэл маш бага гэсэн ангиллаас нийт 96 хариулт сонгогджээ. Эрсдэл бага гэсэн ангиллаас 33, дунд 27, өндөр 17, эрсдэл маш өндөр 19 байна. Бэлэн мөнгөний эрсдэл өндөр байх магадлал сонгогдсон нийт хариултын 9 хувь, маш өндөр байх магадлал 10 хувь байна.

Дансны авлагатай холбоотой эрсдэлд суурилсан аудитын эрсдэл маш бага гэсэн ангилалд 85, бага 44, дунд 22, өндөр 10, маш өндөр 11 хариулт сонгогджээ. Дансны авлагын эрсдэл өндөр байх магадлал 13 хувь, маш өндөр байх магадлал 9 хувь байна.

Бараа материалтай холбоотой эрсдэл суурилсан аудитын эрсдэл маш бага гэсэн ангилалд хамаарагдах магадлал 49 хувь, бага 26 хувь, дунд 13 хувь бол эрсдэл өндөр болон маш өндөр гэсэн ангилалд хамаарагдах магадлалууд ижил 6 хувь байна.

Эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын 40 хувь нь эрсдэл маш бага, 28 хувь нь эрсдэл бага, 17 хувь нь эрсдэл дунд гэсэн ангилалд хамаарагдаж байгаа бол 9 хувь нь эрсдэл өндөр, 7 хувь нь эрсдэл маш өндөр гэсэн магадлалтай байна.

Хүснэгт 4. Эрсдэлд суурилсан аудитын өр төлбөр ба эздийн өмчийн талын санал асуулгын нэгтгэл

Богино хугацаат өр төлбөр			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-4	50	40%
Эрсдэл бага	5-7	37	29%
Эрсдэл дунд	8-10	25	20%

Эрсдэл өндөр	11-13	10	8%
Эрсдэл маш өндөр	14-16	4	3%
Нийт дүн		126	100%
Урт хугацаат өр төлбөр			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-3	47	45%
Эрсдэл бага	4-6	27	26%
Эрсдэл дунд	7-9	19	18%
Эрсдэл өндөр	10-12	8	8%
Эрсдэл маш өндөр	13-15	4	4%
Нийт дүн		105	100%
Эзэмшигчийн өмч			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-3	41	37%
Эрсдэл бага	4-6	31	28%
Эрсдэл дунд	7-9	20	18%
Эрсдэл өндөр	10-12	12	11%
Эрсдэл маш өндөр	13-15	6	5%
Нийт дүн		110	100%
Хуримтлагдсан ашиг			
Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн түвшинд хамаарагдах асуултуудын жагсаалт	Сонгогдсон нийт хариултын тоо	Магадлал
Эрсдэл маш бага	1-3	41	42%
Эрсдэл бага	4-5	17	17%
Эрсдэл дунд	6-8	21	21%
Эрсдэл өндөр	9-11	8	8%
Эрсдэл маш өндөр	12-14	11	11%
Нийт дүн		98	100%

Эх сурвалж: Магадлалын утгыг (1) томъёоллыг ашиглан тооцов.

Хүснэгт 4-с богино хугацаат өр төлбөртэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын эрсдэл маш бага гэсэн ангиллаас 50, эрсдэл бага 37, дунд 25, өндөр 10, эрсдэл маш өндөр 4 сонгогджээ. Богино хугацаат өр төлбөрийн эрсдэл өндөр байх магадлал сонгогдсон нийт хариултын 8 хувь, маш өндөр байх магадлал 3 хувь байна.


Урт хугацаат өр төлбөртэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын эрсдэл маш бага гэсэн ангилалд 47, бага 27, дунд 19, өндөр 8, маш өндөр 4 хариулт сонгогджээ. Урт хугацаат өр төлбөрийн эрсдэл өндөр байх магадлал 8 хувь, маш өндөр байх магадлал 4 хувь байна.

Эзэмшигчийн өмчтэй холбоотой эрсдэл суурилсан аудитын эрсдэл маш бага гэсэн ангилалд хамаарагдах магадлал 37 хувь, бага 28 хувь, дунд 18 хувь бол эрсдэл өндөр 11 хувь, маш өндөр 5 хувь байна.

Хуримтлагдсан ашигтай холбоотой эрсдэлд суурилсан аудитын 42 хувь нь эрсдэл маш бага, 17 хувь нь эрсдэл бага, 21 хувь нь эрсдэл дунд гэсэн ангилалд хамаарагдаж байгаа бол 8 хувь нь эрсдэл өндөр, 11 хувь нь эрсдэл маш өндөр гэсэн магадлалтай байна.

Хүснэгт 3 ба 4-н тооцоологдсон магадлалын утгыг ашиглан (4) томъёоллын дагуу санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн хүлээгдэж буй эрсдэлийн үнэлгээг хийж зураг 1-т нэгтгэн харуулав.

Зураг 1. Санхүүгийн эрсдэлийн үнэлгээ



Зураг 1-с харахад санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн эрсдэлийн утга 5.46-6.87 хооронд тооцогдож байна. Ялангуяа бараа материал, урт хугацаат өр төлбөр, богино хугацаат өр төлбөр, эзэмшигчийн өмч, бэлэн мөнгөтэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын санхүүгийн эрсдэлийн үнэлгээ нь 5.46-6.36 хооронд байгаа нь эрсдэлийн түвшингийн 4-6 гэсэн интервалд хамаарагдах тул эрсдэл бага байна. Бусад дансны авлага, хуримтлагдсан ашиг зэрэг үзүүлэлтийн эрсдэлийн үнэлгээ 6.80-6.87 хооронд байгаа нь эрсдэлийн түвшингийн 7-10 гэсэн интервалд хамаарагдах тул эрсдэл дунд байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар эрсдэлд суурилсан аудитын санхүүгийн эрсдэлийг тодорхойлох нэгэн хувилбарыг авч үзлээ. Тус хувилбар нь эрсдэлийн түвшинг шууд тодорхойлсон эрсдэлд суурилсан аудитын санал асуулга дээр үндэслэгдэнэ. Судалгааны санал асуулга нь 163 асуулгаас бүрдэх ба 10 салбарын нийт 55 аж ахуй нэгж байгууллагыг хамруулсан. Тус судалгаанд санал асуулгыг эрсдэлийн түвшингээр нь багаас их рүү эрэмбэлэн харгалзах магадлалыг тооцон, түүнийг эрсдэлийн дундаж интервалаар үржүүлэн тодорхойлсон арга зүйг ашигласан. Судалгааны нэгтгэлийн дүнд эрсдэл суурилсан аудитаар нийт хөрөнгийн 6-13 хувь нь эрсдэл өндөр, 6-10 хувь нь эрсдэл маш өндөр бол өр төлбөр ба эзний өмчийн 8-11 хувь нь эрсдэл өндөр, 3-11 хувь нь эрсдэл маш өндөр гэсэн ангилалд хамаарагдах магадлалтай байна. Санхүүгийн тайлангийн 8 шалгуур үзүүлэлтийн эрсдэлийн үнэлгээгээр авч үзвэл дансны авлага, хуримтлагдсан ашиг зэрэг үзүүлэлтүүд эрсдэл дунд, бусад үзүүлэлтүүд эрсдэл бага гэж тодорхойлогдлоо.

Ашигласан материал

- Arens, A., Elder, R. & Beasley, M. 2017. Auditing and Assurance Services: An Integrated Approach. Pearson Education.
- Christopher, H., Brendan, O. & Jeffrey, U. 2017. Re-theorizing the configuration of organizational fields: the IIRC and the pursuit of 'Enlightened' corporate reporting. Accounting and Business Research, 47(1): 30 –63.
- Demaki, G. O. 2018. Auditing and corporate governance: A study of selected Nigerian companies. Journal of Accounting and Finance, 18(2): 1-10.
- Hayes, R. 2014. Principles of Auditing: An Introduction to International Standards on Auditing. Pearson Education.
- Knechel, W. R. 2007. The Business Risk Audit: Origins, Obstacles, and Opportunities. Accounting, Organizations, and Society, 32(5): 383–408.

- Manson, S. & Zaman, M. 2001. Auditor Communication in an Evolving Environment. *International Journal of Auditing*, 5(2): 133–146.
- Pickett, K. H. S. 2011. *Audit Planning: A Risk-Based Approach*. Wiley.
- Simunic, D. 1980. The Pricing of Audit Services: Theory and Evidence. *Journal of Accounting Research*, 18(1): 161–190.
- Даваажав, С. 2017. Монголын жижиг, дунд бизнесийн санхүүгийн эрсдэлийн удирдлага.
- Мөнхтуяа, Б. 2020. Монгол Улсын томоохон компаниудын эрсдэлд суурилсан аудитын хэрэглээ.
- Отгонбаяр, А. 2019. Эрсдэлд суурилсан аудитын үүрэг ба ач холбогдол.
- Цэцгээ, Ц. 2021. Эрсдэлийн удирдлага: Монголын банкны салбарын туршлага.
- Энхцэцэг, Б. 2020. Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд.

ХАВСРАЛТ А

Бэлэн мөнгөтэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Мөнгөн гүйлгээний тодорхой төлөвлөгөөтэй байх
2. Бэлэн мөнгөний өдөр тутмын гүйлгээг нарийн хянаж, хяналтын системтэй байх
3. Тайлангийн систем нь ил тод, байнга хянагддаг.
4. Хөрвөх чадвар өндөртэй нөөц мөнгө байнга хангалттай байх
5. Санхүүгийн хяналтын процесс сайн хөгжсөн байх
6. Мөнгөн гүйлгээний төлөвлөлт байгаачлан, заримдаа биелүүлэлтээс зөрөх магадлалтай
7. Бэлэн мөнгөний удирдлагын тодорхой систем байгаа боловч заримдаа хяналт сулрах тохиолдол гарч болзошгүй
8. Авлага болон төлбөрийн хуваарийг удирдахдаа бага зэрэг хоцрогдолтой байж магадгүй
9. Тайлан ба хяналтын систем сайн боловч бага зэргийн доголдол үүсэх боломжтой
10. Бэлэн мөнгөний урсгалын төлөвлөлт хангалтгүй, гэнэтийн зардлууд гарах магадлалтай
11. Авлага болон богино хугацаат өр төлбөрийн төлөвлөгөө сул, тэдгээрийг зохицуулах явцад алдаа гарах эрсдэлтэй
12. Мөнгөн гүйлгээнд санхүүгийн хяналт хангалтгүй тул тооцоо зөрөх, мөнгөн хөрөнгийн дутагдалд орох магадлалтай
13. Гэнэтийн орлого, зардлын өөрчлөлтүүдийг урьдчилан тооцоолохгүй байх магадлалтай
14. Мөнгөн гүйлгээний төлөвлөлтгүй, богино хугацааны санхүүгийн хүндрэлийг даван туулах чадвар сул
15. Авлага хэтрэлттэй, төлбөрийн хугацаа хоцрох эрсдэл ихтэй
16. Мөнгөн хөрөнгө хангалтгүй эсвэл буруу зарцуулалт ихтэй.
17. Мөнгөн гүйлгээнд санхүүгийн хяналт сул, тайлан ба хяналтын систем доголдолтой.
18. Санхүүгийн хяналт, тайлангийн чанар хангалтгүй, алдаа гаргах магадлал өндөр
19. Мөнгөн гүйлгээний зохион байгуулалт байхгүй, мөнгөний алдагдал ихтэй.
20. Авлага ба төлбөрийг хянах систем байхгүй эсвэл сул.
21. Мөнгөн хөрөнгийн дутагдал байнга үүсэх, мөнгөний урсгалыг буруу төлөвлөснөөс үүссэн зардал ихтэй байх
22. Санхүүгийн хяналтын систем бүрэн алдагдсан, тайлан гаргалт маш сул

23. Санхүүгийн хяналтын чанар маш муу, алдаа ихтэй, ил тод байдлыг хангадаггүй

Авлагатай холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Авлагын хяналт, цуглуулалтын систем маш сайн, тогтмол хяналттай.
2. Зээлдэгчдийн зээлийн түүх, эрсдэлийг нарийн үнэлж, сонгон шалгаруулалт хийдэг
3. Гэрээний нөхцөл тодорхой, цаг хугацааны хувьд тодорхой төлөвлөгөөтэй.
4. Бүх авлага богино хугацаанд цуглардаг, хугацаа хэтрэх тохиолдол бараг үгүй.
5. Санхүүгийн хяналт, тайлан маш нарийн байдаг тул алдаа гаргах магадлал бага.
6. Авлагын цуглуулалт ерөнхийдөө сайн боловч зарим нэгэн зээлдэгчдийн төлбөр төлөлт хоцрох магадлалтай.
7. Заримдаа зээлийн баталгааг хангалттай үнэлэхгүй орхих.
8. Авлага цуглуулалтыг хийх процесс тодорхой боловч заримдаа дутмаг хяналт гарч болзошгүй.
9. Санхүүгийн тайлангийн хяналт сайн боловч зарим бага хэмжээний доголдол үүсэж магадгүй.
10. Төлбөрийн нөхцөл тодорхой боловч зээлийн нөхцөлийг хангалттай үнэлдэггүйгээс үүдэн хоцрогдол гарч магадгүй.
11. Авлагын цуглуулалтын хуваарьт хоцрогдол байнга гардаг.
12. Хугацаа хэтэрсэн авлагын тоо нэмэгдэх хандлагатай байдаг.
13. Авлагын хяналт дутмаг, хяналтын механизм тодорхой бус.
14. Санхүүгийн хяналтын чанар дунд зэрэг, тайлангийн нарийвчлал дутмаг.
15. Зээлдэгчдийг сонгон шалгаруулах систем муу, эрсдэл өндөртэй зээлдэгчидтэй хамтран ажиллах магадлал өндөр.
16. Авлагын хугацаа байнга хэтрэх, цуглуулалт удаан хийгдэх.
17. Төлбөрийн нөхцөл болон гэрээний нөхцөл тодорхойгүй эсвэл зөрчилдөөнтэй байх.
18. Зээлийн нөхцөлийг хэт сул тавих, баталгаа хангалтгүй авах.
19. Санхүүгийн хяналт, тайлангийн систем доголдолтой, алдаатай тооцоо гаргах магадлалтай.
20. Зээлийн үнэлгээ бараг хийгддэггүй, хяналт сул тул эрсдэлтэй зээлдэгчидтэй олон удаа гэрээ байгуулдаг
21. Авлагын хяналт огт байхгүй, цуглуулалт бараг хийгддэггүй, авлага алдрах магадлал өндөр.
22. Зээлдэгчдийн төлбөрийн чадваргүйдлийн улмаас авлага цуглуулалт тасалдах, санхүүгийн алдагдал ихтэй байх.

23. Гэрээний нөхцөлүүд тодорхойгүй, авлагын баталгаагүй, зөрчилтэй байдал үргэлжлэн гардаг.
24. Аудитын хяналт огт байхгүй эсвэл маш сул, санхүүгийн тайлан үнэн зөв биш, зөрүү ихтэй гардаг.

Бараа материалтай холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Бараа материалын бүртгэл маш сайн хийгдсэн, нарийвчлал өндөр.
2. Бараа материалын урсгал, бүртгэл тогтмол шинэчлэгддэг.
3. Автоматжуулсан хяналтын системтэй, бараа материалын үлдэгдлийг өдөр бүр хянадаг
4. Санхүүгийн тайлан болон бараа материалын бүртгэл хоорондоо бүрэн нийцдэг.
5. Бараа материалын тооллого, аудит тогтмол хийгддэг.
6. Хяналтын системийн доголдол үүсэхгүй байх.
7. Бараа материалаын үлдэгдэл байнга хянагддаг тул алдагдал болон хорогдол гардаггүй.
8. Бараа материалын хяналт ерөнхийдөө сайн боловч заримдаа бага зэргийн доголдол гарч болзошгүй.
9. Бараа материалын бүртгэл тогтмол хийгддэг боловч зарим мэдээлэл хоцрогдолтой байж болзошүй.
10. Хяналтын систем сайн боловч зарим үед гараар хийх шаардлага гарч, алдаа үүсэх эрсдэлтэй.
11. Бараа материалын бүртгэл заримдаа хугацаанаасаа хоцрох.
12. Бараа материалын тооллого хийх үед бага зэргийн зөрүү гарах.
13. Бараа материалын хяналтын систем сул, бүртгэл хоцрогдолтой байж магадгүй.
14. Бараа материалын урсгалын бүртгэл зөрүүтэй байх магадлалтай.
15. Санхүүгийн тайлан болон бараа материалын бүртгэл зөрүүтэй гарч болзошгүй.
16. Хяналтын систем автомат бус эсвэл гар ажиллагаатай тул алдаа гарах магадлал өндөртэй.
17. Бараа материалын хяналт болон бүртгэлд алдаа гарах.
18. Зохицуулалтгүй агуулахын удирдлагаас үүдэн алдагдал, хорогдол их гарах.
19. Бараа материалын бүртгэлд томоохон алдаа гарч, алдагдал ихтэй байдаг.
20. Хяналтын систем бүрэн автоматжуулагдаагүй, хүний гараар бүртгэл хийхэд алдаа их гардаг.
21. Бараа материалын хэт их хорогдол эсвэл хулгай үүсэх эрсдэл өндөр.

22. Санхүүгийн тайлан болон бараа материалын тоо хэмжээ их хэмжээгээр зөрүүтэй гардаг.
23. Агуулахын зохион байгуулалт муу байх.
24. Бараа материалын хадгалалт, тээвэрлэлтэд зохицуулалт сул байж, эвдрэл хорогдол их үүсэх.
25. Бараа материалын хяналтын систем байхгүй, бүртгэл огт хийгддэггүй эсвэл маш сул.
26. Бараа материалын хэт их хорогдол, алдагдал байнга гардаг.
27. Бараа материалын хадгалалт, агуулахын зохион байгуулалт маш муу.
28. Бараа материалын үлдэгдэл, хорогдлын бүртгэл огт хийгддэггүй эсвэл ихээхэн алдаатай.
29. Хулгай, алдагдал байнга гардаг ч хянаж чаддаггүй.
30. Хяналтгүй агуулахын ажиллагаанаас үүдэн их хэмжээний хорогдол, алдагдал үүсэх.
31. Бараа материалын тайлан болон санхүүгийн тайлан хоорондоо огт нийцэхгүй, ноцтой хохирол үүсэх магадлалтай.

Эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Засвар үйлчилгээ, элэгдэлд хяналт тавих систем сайн хөгжсөн.
2. Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг нарийн тооцоолж, шаардлагатай засвар үйлчилгээ хийгддэг.
3. Хөрөнгийн элэгдлийг байнга хянаж, бүртгэлүүд санхүүгийн тайлантай нийцдэг.
4. Аудитын хяналт байнга хийгдэж, элэгдлийн бүртгэлд алдаа гардаггүй.
5. Сайн хяналт, төлөвлөлттэй холбоотойгоор хөрөнгийн элэгдлийн зөрүү гарах магадлал бага.
6. Засвар үйлчилгээ сайн боловч заримдаа бага зэрэг хоцорч хийгддэг.
7. Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг тооцоолохдоо заримдаа алдаа гарч магадгүй.
8. Элэгдлийн бүртгэл ерөнхийдөө нарийн боловч бага зэргийн доголдол үүсэж болзошгүй.
9. Зарим тоног төхөөрөмжийг хэт удаан хугацаанд ашиглах.
10. Засвар үйлчилгээ хийх хугацаа бага зэрэг хоцорч, элэгдэл хурдан үүсэх боломжтой.
11. Суурь хөрөнгийн засвар үйлчилгээ хоцрогдсон, ашиглалтын хугацааг зөв тооцоолоогүйгээс элэгдэлд орсон.
12. Элэгдлийн бүртгэл дутуу хийгдэж, хөрөнгийн бодит элэгдлийг тооцоолж чадахгүй байх магадлалтай.
13. Хөрөнгийн засвар үйлчилгээ төлөвлөснөөс хоцорч, ашиглалт багасах

магадлалтай.

14. Бүртгэлийн алдаа болон засвар үйлчилгээ хоцрох.
15. Хөрөнгийг ашиглах хугацааг хэтрүүлэн ашиглаж, элэгдлийн асуудал үүсэх.
16. Суурь хөрөнгийн хяналт сул, ихэнх хөрөнгүүд элэгдэлд орсон байхад зохих засвар үйлчилгээ хийгдээгүй.
17. Элэгдэл буруу тооцогдсон эсвэл бүртгэл хоцрогдсон.
18. Хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор засвар үйлчилгээ хийхгүй байх, хөрөнгө муудах магадлалтай.
19. Засвар үйлчилгээ, хяналтын систем сул.
20. Хөрөнгийг удаан хугацаанд ашиглаж, элэгдлийн эрсдэлийг үл тоомсорлох.
21. Хяналт, засвар үйлчилгээ огт хийгддэггүй, хөрөнгө элэгдэлд бүрэн орж, ажиллагаагүй болох магадлалтай.
22. Элэгдэлд хяналт тавих систем огт байхгүй, хөрөнгийн ашиглалтын хугацааг тооцоолоогүйгээс алдагдал хүлээдэг.
23. Тоног төхөөрөмж эвдэрч, дахин засварлах боломжгүй болох, томоохон санхүүгийн хохирол учруулж болзошгүй.
24. Элэгдлийг огт хянаагүйгээс тоног төхөөрөмж, хөрөнгө бүрэн эвдэрч, ашиглах боломжгүй болох.
25. Засвар үйлчилгээ хийгдээгүйгээс хөрөнгө хэт элэгдэлд орж, солих шаардлагатай болох.

Богино хугацаат өр төлбөртэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Мөнгөн урсгал сайн зохицуулагдсан, бэлэн мөнгөний нөөц хангалттай.
2. Өр төлбөрийн төлөвлөлт, хяналтын систем сайн.
3. Төлбөрийн хуваарьт ягштал нийцсэн байдлаар төлбөрүүд хийгддэг.
4. Санхүүгийн тайлан, хяналт байнга шинэчлэгддэг.
5. Мөнгөн урсгал ерөнхийдөө сайн боловч зарим үед бага зэргийн хоцрогдол гарч болзошгүй.
6. Өр төлбөрийг хугацаандаа төлөх үйл явцад заримдаа бага зэргийн асуудал үүсэх.
7. Санхүүгийн хяналт сайн ч, бага зэргийн алдаа, зөрүү гарч магадгүй.
8. Мөнгөн урсгал тогтворгүй, зарим өр төлбөрийн төлөлт хойшлох.
9. Өр төлбөрийн төлөвлөлт хангалтгүй эсвэл төлөвлөснөөс хоцорч хийгдэх.
10. Төлбөрийн удирдлага болон хяналтын систем дутмаг, хугацаа хэтрэх эрсдэл ихсэх.
11. Мөнгөн урсгал тогтворгүй эсвэл ноцтой доголдолтой, төлбөрийн

хугацаа тогтмол хэтэрдэг.

12. Санхүүгийн удирдлагын хяналт сул.
 13. Богино хугацаат өр төлбөрийг зохицуулах төлөвлөгөө байхгүй, эсвэл хэрэгжүүлэх боломжгүй.
 14. Мөнгөн урсгал маш тогтворгүй, санхүүгийн төлөвлөлт байхгүй эсвэл огт хэрэгждэггүй.
 15. Төлбөрийн хяналтгүй, өр төлбөрийн үүргийг биелүүлж чадахгүй болох.
 16. Санхүүгийн ноцтой хохирол үүсэж, дампуурах эрсдэл өндөр.
- Урт хугацаат өр төлбөртэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга
1. Төлбөрийн төлөвлөлт, хуваарь нарийн зохицуулагдсан.
 2. Санхүүгийн урт хугацааны төлөвлөлт сайн.
 3. Урт хугацаат өр төлбөрийн хяналтын систем үр ашигтай ажилладаг.
 4. Мөнгөн урсгал бага зэргийн доголдолтой ч ихээхэн асуудал үүсэхгүй.
 5. Төлбөрийн удирдлага сайн боловч зарим төлбөр хоцрох магадлалтай.
 6. Санхүүгийн төлөвлөлт хангалттай боловч төлөвлөгөө биелэлт дутмаг байх боломжтой.
 7. Төлбөрийн хуваарьт доголдол гарч, төлбөр хоцрох магадлалтай.
 8. Санхүүгийн урт хугацааны төлөвлөлт сул, өр төлбөрийг хугацаанд нь төлөхөд хүндрэл учирч болзошгүй.
 9. Хяналтын систем дутмаг, урт хугацаат төлбөрийн хяналт сул.
 10. Урт хугацаат өр төлбөрийн хяналт сул, их хэмжээний төлбөр хойшлогдох.
 11. Санхүүгийн төлөвлөлт муу, төлбөрийг хуваарийн дагуу төлөх боломжгүй болох.
 12. Хяналтын тогтолцоо дутагдалтай, өр төлбөр хуримтлагдах эрсдэл өндөр.
 13. Урт хугацаат өр төлбөр бараг хянагддаггүй, ихэнх төлбөрийн хугацаа хэтрэх.
 14. Санхүүгийн ноцтой хохирол учирч, өр төлбөрийн удирдлага хяналтгүй болсон.
 15. Өр төлбөрийн төлөлт удаан хугацаанд хойшлогдсоноос санхүүгийн тогтвортой байдал алдагдах магадлал өндөр.

Эздийн өмчтэй холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Эзэмшигчийн өмчийн үнэлгээ зах зээлийн нөхцөлтэй нийцэж, бодит үнэлгээгээр тогтмол шинэчлэгддэг.
2. Хөрөнгийн бүртгэл, үнэлгээ нарийн хийгддэг бөгөөд аудит тогтмол хяналт тавьдаг.
3. Зах зээлийн хэлбэлзэлд хурдан дасан зохицож, санхүүгийн тайлантай

уялдаа холбоотой байдаг.

4. Эзэмшигчийн өмчийн үнэлгээ ерөнхийдөө сайн боловч бага зэргийн зөрүү гарч болзошгүй.
5. Зах зээлийн өөрчлөлтөөс шалтгаалан үнэлгээнд заримдаа бага зэргийн өөрчлөлт орж болзошгүй.
6. Хөрөнгийн үнэлгээнд бага зэргийн хоцрогдол үүсэх магадлалтай.
7. Эзэмшигчийн өмчийн үнэлгээнд зөрүү гарч, зарим хөрөнгө зах зээлийн бодит үнэлгээнээс доогуур үнэлэгддэг.
8. Үнэлгээний систем, хяналт сул байх магадлалтай.
9. Үнэлгээ хоцрогдох, эсвэл бүрэн шинэчлэгдээгүй байх нь эрсдэлийг нэмэгдүүлнэ.
10. Эзэмшигчийн өмчийн үнэлгээ дутуу хийгдсэн эсвэл буруу тооцоологдсон.
11. Зах зээлийн үнэ цэнээс хэт зөрүүтэй үнэлгээ гарч, санхүүгийн тайлан зөрүүтэй гарах магадлалтай.
12. Үнэлгээний хяналт сул эсвэл бүрэн доголдолтой байх.
13. Эзэмшигчийн өмчийн үнэлгээ огт хийгддэггүй эсвэл маш сул хийгдсэн, бодит үнэлгээг тооцоолох боломжгүй.
14. Зах зээлийн хэлбэлзэлд огт нийцэхгүй, өмчийн үнэлгээний систем алдагдсан.
15. Үнэлгээнд ноцтой алдаа гарч, санхүүгийн тайлан болон бодит байдал хоорондоо огт нийцэхгүйд хүрэх.

Хуваарилагдаагүй ашигтай холбоотой эрсдэлд суурилсан аудитын асуулга

1. Нөөц болон хуваарилагдаагүй ашиг сайн хянагддаг, ашиглалтын төлөвлөгөө тогтмол байдаг.
2. Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, ашгийг үр дүнтэй хуваарилдаг.
3. Аудитын хяналт байнга хийгдэж, нөөц болон ашиглалтын зөрчил гардаггүй.
4. Нөөцийн хяналт сайн боловч зарим үед бага зэргийн хоцрогдол үүсэж магадгүй.
5. Ашиглалтын хуваарилалтад бага зэрэг алдаа гарч, санхүүгийн тайлантай зөрүү үүсэх боломжтой.
6. Нөөц болон хуваарилагдаагүй ашигт хяналт дутмаг, ашиглалтын төлөвлөгөө алдаатай байх магадлалтай.
7. Санхүүгийн тайланд нөөцийн талаархи мэдээлэл дутуу, зөрүүтэй байх.
8. Ашгийн хуваарилалтанд зөрүү гарч, компани санхүүгийн асуудалд орох эрсдэлтэй.
9. Нөөц болон хуваарилагдаагүй ашиг хяналтгүй, ашиглалтын төлөвлөгөө тодорхой бус.

10. Санхүүгийн тайлангууд болон бодит нөөцийн удирдлага хоорондоо нийцэхгүй байх магадлалтай.
11. Ашиг алдагдах эсвэл зүй бусаар хуваарилагдах.
12. Нөөц болон хуваарилагдаагүй ашигт огт хяналт байхгүй, алдагдалд хүргэх ноцтой асуудлууд гарч болзошгүй.
13. Ашиглалтын төлөвлөлт, хяналтын систем байхгүйгээс санхүүгийн тогтвортой байдал алдагдах магадлалтай.
14. Нөөцийн алдагдал, буруу хуваарилалт ихээр гарч, компанийн үйл ажиллагаа доголдох эрсдэл өндөр